



ХУНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД ЗАГДЖАВЫН  
МЭНДСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, факс: 32-70-18  
E-mail: stategreatnurtail@parliament.mn  
http://www.parliament.mn

2021.03.31 № 60

Г Асуулга тавих тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хетэлbert "Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын суу үйлдвэрлэл, боловсруулалтыг ёсгэж, сүүгээ борлуулж буй малчдад сүүний урамшуулал олгох тогтолцоог бий болгоно" гэж тусгасны дагуу 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох түр журам"- ыг батлан хэрэгжүүлж байгаа билээ.

Улсын Их Хурлын гишүүн миний нэр дээр малчид, фермерийн аж ахуй эрхлэгчдээс сүүний мөнгөн урамшуулал олголтын талаар ирүүлсэн шүүмжлэл, саналтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн Танд хандан дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Сүү боловсруулах үйлдвэр, цехэд малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмын хэрэгжилтийн явц, үр дүн, шүүмжлэлд туссан асуудлын тайлбар;
2. Дотоодын сүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээ, хуурай сүүний импортын талаар;
3. Сум, орон нутаг дахь мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, үйлчилгээний төлбөрийн талаар;
4. Сумын гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадамж, өвөөгийн нөхцөл байдал болон цаашид чадавхижуулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар;

Асуулгын хариут Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг Танаас хүсье.

Хавсралт 4 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Н.ЭНХБОЛД

2022000015